



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/266

Чингис хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар Сонгдо эмнэлгээс хэрэгжүүлж буй "Зүрх мартахгүй" төслийн хүрээнд зүрхний гажигийн мэс засалд яаралтай хамрагдах шаардлагатай Хэнтий аймгийн харьяат 4 хүүхдийн эмчилгээний зардалд зориулж 1,000,000 (нэг сая) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

06 Аймгийн Засаг даргын 2021 оны
дугаар сарын 02 өдрийн А/266
дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

Д/д	Хүний тоо	Нэг хүнд оногдох мөнгөн дүн	Дүн
1	4	250,000	1,000,000
Нийт			1,000,000